



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2026 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад заасан 1 /нэг/ хуулийн этгээдэд “Дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгосугай.
2. Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүлээн авсан этгээд түүнийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдтэй зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД

М.БАТТУЛГА

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Б.МЯГМАРНАРАН

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2026 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн  
49 тоот тогтоолын  
хавсралт



Тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн  
жагсаалт

№	Хуулийн этгээдийн нэр	Хамрах хүрээ, Үйлчилгээний хүртээмж	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
1	Стар трий блүүм ХХК	Дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Шуудангийн нэмэлт үйлчилгээ/	2026.04.16	2031.04.16

----- оОо -----